

ЯПОНЫ УЛС ТӨРИЙН ТОГТОЛЦООНД ПАРЛАМЕНТИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

*У.Загдцэсэм**

Япон Улс бол Парламентийн өвөрмөц түүхтэй орон юм. Японы анхны Их хурал нь 1889 он буюу Мэйжигийн 22 дугаар онд нээгдэж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн Эзэнт улсын Их хурал юм. Энэ Их хурал 1947 он буюу Шёвагийн 22 дугаар онд өнөөгийн Парламент Үндсэн хуулиар батлагдан үйл ажиллагаагаа явуулж эхлэх хүртэл үйл ажиллагаагаа явуулж байжээ. Эзэнт улсын Их хурал нь төрийн эрх барих дээд байгууллага, хууль тогтоох цорын ганц байгууллага байсангүй тэр үед эзэн хаан энэ эрхийг эдэлж байв. Мөн Зөвлөхүүдийн танхим нь Төлөөлөгчдийн танхимаас давуу эрхийг эдэлж байсан ба энэ танхимд эзэн хааны угсааны эрх мэдэлтнүүд үйл ажиллагаа явуулдаг байжээ.

Тэгвэл Дэлхийн II дайны дараа Японы улс төрийн тогтолцоонд үндсэн өөрчлөлт орсон юм. Япон улсын өнөөгийн улс төрийн тогтолцоо нь хууль тогтоох /парламент/, гүйцэтгэх /кабинет буюу засгийн газар/, шүүх гэсэн засаглалын гурван хэлбэрийн бие даасан байдлыг тунхаглан тодорхойлж, харилцан хяналттай үйл ажиллагаагаа явуулдаг тогтолцоо юм. Харин уг тогтолцоонд дээрх засаглалын гурван байгууллага нь бүрэн биеэ дааж, салангид үйл ажиллагаа явуулдаг бус харин ч харилцан хамааралд оршиж, харилцан тэнцвэртэй үйл ажиллагаа явуулдаг байна.

1947 оны 5-р сарын 3-ны өдрөөс эхлэн хэрэгжиж буй Япон улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлд зааснаар “Японы үндэсний их хуралдаан болох Парламент нь төрийн эрх барих дээд байгууллага, төрийн хууль тогтоох цорын ганц байгууллага юм” гэж заасан байдаг.

Мөн Япон улсын Үндсэн хуулийн 42 дугаар зүйлд “Парламент нь Төлөөлөгчдийн танхим болон Зөвлөхүүдийн танхимаас бүрдэж үйл ажиллагаагаа явуулна” гэж заасан ба хуулийн төсөл, улсын төсөв хэлэлцэх, гэрээ хэлэлцээрийг батлах, засгийн газрын тэргүүн ерөнхий сайдыг нэр дэвшүүлэх зэрэгт хоёр танхимд санал зөрөлдсөн тохиолдолд Төлөөлөгчдийн танхимын саналаар тогтдог.

Японы Парламентийн үйл ажиллагаа нь Үндсэн хууль, 1947 оны 6 дугаар сарын 28-нд батлагдсан “Төлөөлөгчдийн танхимын дүрэм” 1949 оны 6 дугаар сарын 28-нд батлагдсан “Зөвлөхүүдийн танхимын дүрэм”-ийн заалтын дагуу хэрэгждэг.

Хууль тогтоох дээд байгууллага парламент нь гүйцэтгэх болон шүүх засаглалын дээд байгууллагатай хэрхэн үйл ажиллагааны холбоо хамааралтай байдаг талаар энд цухас авч үзье.

*У.Загдцэсэм - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистрант

Парламент болон Засгийн газрын харилцан хамаарлын хувьд гол нь Засгийн газрыг Парламентийн гишүүдийн дотроос томилдог ажээ. Өөрөөр хэлбэл Япон улсын Засгийн газар нь гүйцэтгэх засаглалын эрхээ хэрэгжүүлэхдээ парламенттэй нягт холбоотой байж, түүний өмнө тодорхой хариуцлага хүлээдэг /Үндсэн хуулийн 67-р зүйл/ байна. Парламент нь засгийн газрын ерөнхий сайдыг парламентийн гишүүдийн дотроос нэр дэвшүүлдэг, мөн засгийн газрын гишүүдийн талаас илүү хувь нь парламентийн гишүүдээс бүрддэг /Үндсэн хуулийн 66, 67-р зүйл/ ажээ. Ийнхүү парламентад олонхи суудлыг авсан нам, эвсэл Засгийн газрыг байгуулж, парламент засгийн газрын үйл ажиллагааны нэгдлийг зохицуулдаг аж. Төлөөлөгчдийн танхим нь Засгийн газарт итгэл үл үзүүлэх шийдвэр гаргах эрхтэй бөгөөд ийм тохиолдолд засгийн газрын тэргүүн Төлөөлөгчдийн танхимыг тараах эрхтэй байдаг. Хууль тогтоох эрх парламентад халгалагдах бөгөөд засгийн газар нь хуулийн төслийг өргөн барих эрхтэй байдаг.

Парламент болон шүүх засаглалын харилцан хамаарлын тухайд Шүүх нь парламентаас батлан гаргасан хууль Үндсэн хуулийн агуулгад нийцэж буй эсэхийг хянан үзэх эрхийг эдэлдэг. Харин парламентийн хувьд ерөнхий шүүгчийг ажил үүргээс нь халах, шүүх хурлыг явуулах парламентийн гишүүдээс бүрдсэн импечмент /impeachment/-ийг байгуулдаг.

Засгийн газар болон Шүүхийн холбоо хамаарлын тухайд Засгийн газрын тогтоол гаргаж түүнд үндэслэн Засгийн газрын байгууллагаас гаргаж буй шийдвэр, дүрэм, журам Үндсэн хуулийн агуулгад нийцэж байгаа эсэхийг шүүхээс хянан үздэг. Харин засгийн газрын тэргүүн нь бүрэн эрхийнхээ дагуу Дээд шүүхийн даргыг нэр дэвшүүлж, бусад шүүгчдийг томилдог байна.

Ийнхүү парламент, засгийн газар, шүүхийн хооронд харилцан хамаарал, харилцан хяналт, харилцан тэнцвэр бүхий үйл ажиллагааны тогтолцоо хэрэгжиж, энэ тогтолцоонд парламент нь төрийн эрх барих дээд байгууллагын байр суурийг халгалж байдаг ажээ.

Япон улсын Парламент нь “хууль тогтоох дээд байгууллага”-ын хувьд хууль батлах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Түүнээс гадна “төрийн эрх барих дээд байгууллага”-ын хувьд ч өргөн эрх эдэлдэг байна. Улсын төсөв батлах зэрэг эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах эрх, гадаад улстай гэрээ хэлэлцээр байгуулахтай холбогдуулан гэрээ хэлэлцээр батламжлах эрх, засгийн газрын ерөнхий сайдыг нэр дэвшүүлэх эрх, Үндсэн хуулинд өөрчлөлт засвар оруулах эрх, хааны ордны төсөв санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргах эрх гэх мэт эрхүүдийг эдэлдэг.

Парламентад хууль боловсруулахын тулд тооцоо судалгаатай нарийн хэлэлцүүлэг явуулсны үндсэн дээр ард түмний бодол санаанд

яв цав нийцэхүйц хууль батлан гаргах үүрэг хүлээдэг. Хуулийн төслийг байнгын хороодод хэлэлцэж улмаар парламентад нягтлан авч үзэж олонхийн саналын үндсэн дээр хууль батлагддаг журамтай. Парламентад батлагдах хуулийн төслийг хоёр танхимаар дамжуулан оруулж батлуулдаг. Хуулийн төслийг парламентаар авч хэлэлцэхэд нэг танхим 5 өдрийн дотор хэлэлцэж нөгөө танхимдаа шилжүүлэх журамтай. Үндсэн хуулийн дагуу парламентаар хуулийн төслийг авч хэлэлцэхдээ хоёр танхимын олонхийн саналыг харгалзан үздэг хэдий боловч энэ асуудал дээр Төлөөлөгчдийн танхим давамгайлах үүрэг гүйцэтгэнэ. Зөвлөхүүдийн танхимаас хуулийн төслийг батлахаас татгалзсан тохиолдолд Төлөөлөгчдийн танхимд асуудлыг хоёр дахь удаагаа авч хэлэлцэн, энэ танхимын гишүүдийн гуравны хоёр нь дэмжиж байвал хуулийн төсөл хүчин төгөлдөр болдог байна. Парламентийн баталж гаргасан хуулиудыг Дээд шүүхээс хянаж, хэрэв Үндсэн хуулийн заалтад эс нийцсэн гэж үзвэл уг хуулийг хүчингүйд тооцно.

Үндсэн хуульд зааснаар Парламентад улсын санхүүг зохицуулах бүрэн эрхийг олгодог бөгөөд Засгийн газраас боловсруулж оруулсан Япон улсын төсвийн төслийг жил бүр Парламентад баталдаг. Төсвийн асуудлыг Төлөөлөгчдийн танхимд эхлэн хэлэлцэж батлан дараа нь Зөвлөхүүдийн танхимд хэлэлцэх ба хэрвээ хоёр танхимын санал зөрөлдөх, 30 хоногийн дотор Зөвлөхүүдийн танхимд хэлэлцэн батлаж чадахгүйд хүрвэл төсвийг Төлөөлөгчдийн танхимынхаар шийдвэрлэдэг.

Засгийн газрын тэргүүн ерөнхий сайдыг нэр дэвшүүлэх үүргийн тухайд Парламент нь ерөнхий сайдыг Парламентийн гишүүдийнхээ дотроос нэрийг нь дэвшүүлэн сонгодог. Ерөнхий сайдыг нэр дэвшүүлэх эрх эдэлж буй нь мөн огцруулах эрх эдлэхийг харуулна.

Парламентийн ээлжит чуулганыг жилд нэг удаа зарлан хуралдуулахаас гадна ээлжит бус чуулганыг Сайд нарын Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн хуралдуулна. Чуулганы үргэлжлэх хугацааг Парламентийн хоёр танхимын гишүүдийн саналыг харгалзан тогтоодог. Парламентийн чуулган хууль эрхийнхээ дагуу нээлттэй байх ёстой бөгөөд олон нийтэд мэдээллийн хэрэгслээр дамжуулан үзүүлдэг. Хурлыг хаалттай нөхцөлд хийсэн ч гэсэн гишүүдийн гуравны хоёр нь зөвшөөрсөн тохиолдолд хурлын протоколыг нийтэлдэг журамтай.

Японы Парламентад өргөн барьсан хуулийн төслийг Парламентийн гишүүний өргөн барьсан хуулийн төсөл, засгийн газар өргөн барьсан хуулийн төсөл хэмээн ялган авч үздэг байна. Парламентийн гишүүн хуулийн төслийг өргөн барих тохиолдолд Төлөөлөгчдийн танхимд 20 хүн, Зөвлөхүүдийн танхимд 10 хүнээс дээш дэмжсэн санал авах шаардлагатай. Парламентийн гишүүн ганц ганцаараа хуулийн төсөл өргөн барьж болохгүй. Мөн төсөвтэй

холбоотой хуулийн төсөл өргөн барихад Төлөөлөгчдийн танхимд 50 хүн, Зөвлөхүүдийн танхимд 20 хүнээс дээш дэмжсэн санал хэрэгтэй байдаг байна. Энэ мэтээр гишүүдийн хуулийн төсөл өргөн барих нь тус тусын танхимд дэмжлэг хэрэгтэй учраас Засгийн газрын өргөн барьсан хуулийн төслөөс тооны хувьд бага, хууль болон батлагдах боломж доогуур байдаг байна.

Парламентийн хоёр танхимын бүтэц

Төлөөлөгчдийн танхим	Зөвлөхүүдийн танхим
Танхимын хурлын дарга 1, дэд дарга 1	Танхимын хурлын дарга 1, дэд дарга 1
Байнгын хороо 17	Байнгын хороо 17
Тусгай хороо 5	Тусгай хороо 5
Үндсэн хууль судлах газар 1	Судалгааны газар 3
Улс төрийн судалгаа, хэлэлцүүлэгийн газар 1	Үндсэн хууль судлах газар 1
	Улс төрийн судалгаа, хэлэлцүүлэгийн газар 1

Эх сурвалж: Imidas 2002 хуудас 287

Парламентийн өдөр тутмын үйл ажиллагаанд Парламентийн байнгын хороо болон тусгай хороод чухал үүрэг гүйцэтгэнэ.

Танхим бүр 17 байнгын хороотой. Энэ нь Засгийн газар, орон нутгийн засаг захиргааны хэрэг, хууль зүй, гадаад бодлого, улсын санхүү, боловсрол, нийгэм болон хөдөлмөрийн асуудал, хөдөө аж ахуй ба ойн аж ахуй, худалдаа аж үйлдвэрийн асуудал, зам тээвэр, хүрээлэн буй орчин, аюулгүй байдал, улс төрийн үндсэн бодлого зохицуулалт, холбоо барилга, төсөв, парламентийн дотоод үйл ажиллагаа, сахилга бат хариуцсан хянан шалгах байнгын хороодууд юм. Эдгээр хороодууд тус тусын эрхлэх ажил үүргийн чиглэлээр хуулийн төсөл болон шийдвэрийг эхлэн хэлэлцэн боловсруулж парламентад оруулан хэлэлцүүлдэг байна. Хороо бүр парламентад эзлэх суудлаасаа хамаарч олон намын 20-40 гишүүдтэй байдаг ба өөр өөрсдийн намыг төлөөлж санал бодлоо илэрхийлдэг байна. Мөн Японы Парламентийн онцлог тал нь гэвэл байнгын хороодод асуудлыг хэлэлцэх явцад ард түмний саналыг сайн сонсож шийдвэрлэхгүй бол болохгүй асуудал гарвал ард түмний төлөөллөөс бүрдсэн тусгай хороог зохион байгуулдаг. Жишээ нь улсын төсөв болон ард түмний амьдралд шууд нөлөө үзүүлэхүйц асуудлыг хэлэлцэх явцад энэ тусгай хороонд эрдэмтэн мэргэжилтэн болон энэ асуудалд шууд хамааралтай хүмүүсийг урин саналыг нь сонсдог. Ард түмний саналыг шууд сонсож асуудлыг хэлэлцдэг хороотой нь Японы Парламентийн сайн тал юм.

2000 онд өөрчлөгдсөн олон нийтийн сонгуулийн хуулиар Төлөөлөгчдийн танхим нь 480 гишүүний суудалтай 4 жилийн хугацаатай сонгогддог болсон ба 25 наснаас дээшхи Япон улсын иргэн сонгогдох эрхтэй. Зөвлөхүүдийн танхимын хувьд 242 гишүүний суудалтай, 6 жилийн хугацаатай сонгогддог бөгөөд 30 наснаас дээшхи Япон улсын иргэн сонгогдох эрхтэй байна. Төлөөлөгчдийн танхим хугацаанаасаа өмнө бүрэн бүрэлдэхүүнээрээ тарах тохиолдол байдаг. Харин Зөвлөхүүдийн танхимын бүрэлдэхүүн илүү тогтвортой байдаг бөгөөд хугацаанаасаа өмнө бүрэн бүрэлдэхүүнээрээ тардаггүй 3 жил тутамд гишүүдийн тэн хагас нь шинэчлэгдэн сонгогдож байдаг байна. /Танхимын доторх гишүүдийн дунд хэсэгчилсэн сонгууль болдог/

Төлөөлөгчдийн танхим татан буугдсан үед Засгийн газраас онцгой тохиолдолд Зөвлөхүүдийн танхимыг зарлан хуралдуулж хууль зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх эрхийг олгодог.

Ийнхүү Японы Парламент нь хоёр танхимтай буйн сайн тал нь олонхийн саналд шүүмжлэлтэй хандах, нарийн нягт хэлэлцүүлэг, хоёр танхим хоорондын хүчний тэнцвэрийг хадгалах, нөгөө талаас нэг танхимын үйл ажиллагаа тасалдахад хүрвэл нөгөө танхимд асуудлыг үргэлжлүүлэх сайн талтай хэмээн судлаачид үздэг байна.

Дашрамд дурдахад энэ 2005 оны 9 дүгээр сард Японы Парламентийн Төлөөлөгчдийн танхимын сонгууль болж Либериа ардчилсан нам олонхийн суудал авсан байна.

Ашигласан материал

1. “Япон улсын Үндсэн хууль”. “BIE 15”, Japan 1994
2. “Britannica international encyclopedia 15”. Japan 1994
3. “IMIDAS 2002”. Japan, 2002
4. Ишида Мицүёоши. “Сэйжи но шикүми” Токио, 2004
5. Оояма Рэйко. “Коккай гаку нюүмон” Сансэидо, 2003
6. “Япон орон япончууд” УБ, 1991